



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2020.12.19 № 03/2193

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА НАРТ

Тайлан, судалгаа ирүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 6.1 дэх хэсэгт заасны дагуу Салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланг 2021 оны 01дүгээр сарын 15-ны өдрийн дотор хугацаа хожимдуулалгүй ирүүлэхийг мэдэгдье.

Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын "Гурав" дугаар бүлэгт заасан чиг үүрэг /3.1-3.9 дэх хэсэг/-ийн дагуу салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайланг ирүүлэхдээ хүргүүлж буй хүснэгтүүдийн дагуу мэдээг гаргаж хавсаргана уу.

Тайлан бичих бүтэц, агуулгын талаар зөвлөмж, мэдээ судалгааны хүснэгтийг хавсаргав.

Хавсралт 15 хуудас.

ГИШҮҮН



С.ЦЭДЭНДАМБА

20005860

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ЗӨВЛӨМЖ

Тайлангийн бүтэц нь 3 үндсэн хэсэгтэй, дүгнэлт, санал, хавсралттай байна.

1. Ерөнхий хэсэг:

- салбар зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа болох хурал;
- бусад зохион байгуулалтын үйл ажиллагааг нэгтгэх оруулах;

2. Үндсэн хэсэг:

-төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэгт заасан чиглэл тус бүрээр дэд гарчиг болгон нэгтгэх бичих;

-салбар зөвлөлийн журамд заасан дээрх /74.1/ чиг үүргээс бусад чиг үүргийн дагуу хийсэн ажлаа нэгтгэн бичих;

3. Бусад хэсэг:

-шинээр хийж хэрэгжүүлсэн инновацийн шинжтэй ажил болон ил тод байдал, жендер, авлига, ашиг сонирхол зэрэг бусад үйл ажиллагааг оруулах;

4. Дүгнэлт:

-Тухайн оны үйл ажиллагааны ахиц дэвшлийг өмнөх мөн үеийнхтэй харьцуулан нэгтгэн дүгнэх;

5. Санал:

хууль тогтоомжийн хэрэгжилт болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах тухай;

6: хавсралт:

-хүргүүлж буй хавсралтад дурдсан мэдээ, мэдээллийг бодит байдалд үндэслэн үнэн зөв, гаргах хавсаргах зэрэг болно.

Тайланг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн тэмдэглэлтэй байна.

Жич: Тайлангийн 14 хавсралтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудасны "үйл явдал" хэсгээс татаж авна уу.

_____оОо_____